

Д.НАЦАГДОРЖИЙН ЗОХИОЛЫГ ХЯТАД ХЭЛНЭЭ ОРЧУУЛСАН БАЙДАЛ

(“Шувуун саарал” өгүүллэгийн хятад орчуулгын жишээгээр)

Г.Элдэв-Очир⁹⁴

Товч утга: Их зохиолч Д.Нацагдорж “Шувуун саарал” өгүүллэгээ 1930 онд бичсэн бөгөөд монголчуудын дунд ихэд алдаршсан сайхан зохиол юм. Уг өгүүллэг нь нийт 11 хэсэгтэй, монгол ахуй соёлыг харуулсан, яруу илэрхийллийг нэлээд ашигласан байх агаад ийм агуулгыг хятад хэлнээ хэрхэн орчуулсныг харьцуулан авч үзлээ.

Түлхүүр үг: Шувуун сараал, морь тарлах, хөмсөг мэт сар, харь хошууны нутаг, хуучин сар, зэл, нохой хорих

Монголын орчин үеийн уран зохиолыг үндэслэгч, их зохиолч Д.Нацагдоржийн зохиол бүтээлүүдээс бидний сайн мэдэх “Хуучин хүү”, “Миний нутаг”, “Шувуун саарал”, “Цагаан сар ба хар нулимс”, “Хөдөө талын үзэсгэлэн”, “Ламбугайн нулимс”, “Алс газар сурахаар явагч”, “Миний хэнз хурга”, “Хавар”, “Дөрвөн цаг”, “Тэргий хүүхдээсээ хагацахуй”, “Уул усны охин”, “Харанхуй хад”, “Учиртай гурван толгой” зэргийг хятад хэлнээ орчуулсан байх агаад МУБИС-ийн Боловсролын сургуулийн захирал, доктор, профессор Г.Цогзолмаа эх зохиол болон хятад орчуулгуудыг эмхэтгэн “Д.Нацагдоржийн түүвэр зохиол” нэртэйгээр 2016 онд хэвлүүлсэн нь монгол, хятад орчуулгын чиглэлээр судалгаа шинжилгээ болон орчуулга сонирхон оролддог хэн хүнд нэн чухал гарын авлага болохуйц сайхан бүтээл болжээ.

Энэхүү эмхтгэлд “Шувуун сараал” өгүүллэгийг хятад хэлнээ Хадцагаан болон Цэнь Тяньхуа нарын орчуулсан хоёр хувилбар багтжээ. Иймд уг өгүүллэгийн зарим онцлог содон үг хэллэг, яруу илэрхийлэл зэргийг хятад хэлнээ хэрхэн орчуулсныг харгуулан үзэж, тухайн орчуулга ямар өнгө аястай болсныг судлахыг хичээлээ.

1. “...Ойртон үзвэл хэдэн залуус *морь тарлаж* байна...”

“...寻黑点而至，原来是有几个年轻人正在练马...” /Хадцагаан/

“...进去一看，几个年轻人正在练马...” /Цэнь Тяньхуа/

Эл өгүүлбэрт буй “морь тарлах” хэмээх хэллэгийг “Монгол хэлний их тайлбар толь”-д⁹⁵ “уралдах морины амьсгааг задалж хурд нэмэх, огцом хөдөлгөөнд хөлийн ээдрээ гаргах зорилгоор ойр давхиулах, үсэргэх” гэж тайлбарлажээ. Харин үүнийг хоёр орчуулагч хоёулаа “练马” буюу үгчилэн орчуулбал “морь дасгалжуулах” гэсэн утгаар орчуулсан нь эхийн утгатай ойролцоо болжээ.

2. “...ялгуум саарал морь нь тогтож ядан, гуа сайхан дөрвөн хөлөөр ээлжлэн газар цавчилж...”

⁹⁴ МУИС, ШУС, ХУС-ийн Ази судлалын тэнхим, доктор

⁹⁵ <https://mongoltoli.mn/dictionary/detail/84864>

“...生龙活虎的修长白马，不停地用前蹄刨地...” /Хадцагаан/

“...银合骏马没有站住。它那秀丽的四腿不停地踢蹬大地...” /Цэнь Тяньхуа/

“Ялгуум саарал морь” гэсний “ялгуум” хэмээхүйг “Монгол хэлний их тайлбар толь”-д “ялгуум зөөлөн явдалтай морь (хөнгөн зөөлөн явдалтай морь)” гэж тайлбарлажээ. Үүнийг орчуулагч Хадцагаан “生龙活虎” буюу үгчилэн орчуулбал “ирмүүн гавшгай, хурц шаламгай” гэх утгатай хэлц үгээр орчуулж, харин “саарал морь” гэснийг “修长白马” буюу “өндөр туранхай, цагаан морь” хэмээн эхэд байхгүй үг хэллэг нэмж орчуулсан байна. Харин орчуулагч Цэнь Тяньхуа “ялгуум” хэмээхүйг орчуулалгүй орхиод, шууд “Шувуун саарал морь”⁹⁶ гэдгээр төлөөлүүлэн орчуулжээ. Хоёр орчуулагчийн хувьд аль алин нь “ялгуум” гэх үгт агуулагдах “хөнгөн зөөлөн явдалтай морь” хэмээх утгыг нарийн гарган орчуулж чадсангүй.

3. “...Үүрийн туяа гэгээрэхэд, хөмсөг мэт сар далд ороогүй, дэргэдүүр намрын хяруу гилтгэнэж, тэртээ уулын орой эрвийн сэрвийн үзэгдэнэ...”

“...曙光从地平线露出, 柳眉般的月牙隐去了。近旁, 秋霜闪烁; 远处, 山影嶙峋...” /Хадцагаан/

“...月牙尚没消逝, 秋霜还闪耀着光芒。远山才隐约可见...” /Цэнь Тяньхуа/

Зохиолч эл өгүүлбэрт сарыг хөмсөгтэй зүйрлэж, тухайн үед хавирган сартай шөнө байсныг ийнхүү уншигчдад ойлгомжтой байхаар монгол хэлний яруу илэрхийллийн аргыг чадамгай ашиглаж харуулжээ. Үүнийг орчуулагч Хадцагаан “柳眉般的月牙” гэж яг байгаагаар нь орчуулсан авч “далд ороогүй” гэснийг “隐去了” буюу “далд орсон” болгож орчуулсан нь эхээс зөрүүтэй болгожээ. Орчуулагч Цэнь Тяньхуа “月牙尚没消逝” буюу үгчилэн орчуулбал “сар арай замхараагүй” гэж орчуулснаар “хөмсөг мэт сар” гэсэн зүйрлэлийг огт гаргаж чадаагүй байна. Харин “тэртээ уулын орой эрвийн сэрвийн үзэгдэнэ” гэснийг орчуулагч Хадцагаан “远处, 山影嶙峋” буюу “тэртээ хол уулын бараа арзгар барзгар” гэсэн утгаар орчуулан гаргажээ. Орчуулагч Цэнь Тяньхуа үүнийг “远山才隐约可见” буюу “алсын уулс дөнгөж бүдэг бадаг үзэгдэх төдий” хэмээн ерөнхий утгаар нь тоймлон орчуулсан байна.

4. “...Шувуун саарал нь хазаар даран, хоногийн газрыг өдөрт хүрэхээр тэмүүлэн хатирна...”

“...希布恩 撒日勒俯仰着头, 为把两天的行程一天里赶到而疾步狂颠...” /Хадцагаан/

“...银合飞马低着头, 大步疾走, 尽力想把一昼夜的路程在当天赶到...” /Цэнь Тяньхуа/

Эл өгүүлбэрт буй “хазаар дарах” гэснийг “Монгол хэлний их тайлбар толь”-д “унасан морь жолоо булаах мэт урагш тэмүүлэх” гэж тайлбарлажээ. Үүнийг орчуулагч Хадцагаан “俯仰着头” буюу “толгойгоо бөхөлзөж гэдэлзүүлж” хэмээн орчуулсан байна. Харин орчуулагч Цэнь Тяньхуа “低着头, 大步疾走” буюу үгчилэн

⁹⁶ Орчуулагч Цэнь Тяньхуа “Шувуун саарал морь” гэдгийг “银合飞马” буюу “Шарга хурдан ажнай” гэж орчуулсан.

орчуулбал “толгойгоо бөхийлгөн, том алхаагаар хурдтай давхих” гэж орчуулжээ. Хоёр орчуулагч ерөнхийдөө уг утгыг гаргасан боловч Цэнь Тяньхуа хурдан давхиж буй санааг илүүтэй мэдэрч орчуулсан нь харагдаж байна.

“хоногийн газрыг өдөрт хүрэхээр тэмүүлэн хатирна” гэснийг орчуулагч Хадцагаан “为把两天的行程一天里赶到而疾步狂颠” буюу “хоёр өдрийн замыг нэг өдөрт туулахаар хурдтай давхина” хэмээн орчуулсан бол, Цэнь Тяньхуа “尽力想把一昼夜的路程在当天赶到” буюу “нэгэн шөнийн замыг тэр өдөртөө туулахаар хамаг хүчээ шавхана” хэмээн орчуулснаас харахад, энэ хэсгийн утга санааг Цэнь Тяньхуа нь илүүтэй нарийн орчуулжээ.

5. “...Шувуун саарал морь нь Сүрэнхүүгийн унаа-аа, сүүмэн сүүмэн харагдах нь Сүнжидмаагийн нутаг аа...”

“...苏荣夫心爱的良驹希布恩 撒日勒飞速向前， 苍茫的前方已隐约可见松吉德玛家乡的远影...” /Хадцагаан/

“...飞奔着的骏马是苏仁夫的坐骑。隐约可见的是松吉德玛的家乡...” /Цэнь Тяньхуа/

Энэхүү өгүүлбэр бол монголчуудын дунд ихэд алдаршин түгсэн бөгөөд бараг хэлц хэллэг болтлоо хоногшсон байдаг. Харин үүнийг орчуулагч Хадцагаан “Сүрэнхүүгийн дотно хайртай, сайн хүлэг Шувуун саарал нь дүүлэн нисэх мэт урагш тэмүүлнэ. Сүнжидмаагийн нутгийн бараа өмнө талд цэлийж, бүдэг бадаг харагдана” гэж орчуулжээ. Орчуулагч Цэнь Тяньхуа “Нисэх мэт давхих аргамаг хүлэг нь Сүрэнхүүгийн унаа. Бүдэг бадаг харагдаж буй нь Сүнжидмаагийн нутаг” хэмээн орчуулсан байна. Үүнээс харахад орчуулагч Цэнь Тяньхуа уг эхэд тун ойртуулж, уран яруу сайхан орчуулжээ.

6. “...Харь хошууны нутагт ороход...”

“...踏入相邻艾玛克的土地...” /Хадцагаан/

“...进入邻省...” /Цэнь Тяньхуа/

“Харь хошууны нутаг” гэснийг орчуулагч Хадцагаан “зэргэлдээ аймгийн нутаг” гэж орчуулсан ч “аймаг”-ийг “艾玛克 буюу aimake” гэж галиглажээ. Харин Цэнь Тяньхуа мөн л “зэргэлдээ аймаг” гэж орчуулахдаа “аймаг”-ийг хятад хэлний “省” буюу “муж” гэх утгатай үгээр дүйлгэн орчуулсан байна. Монгол хэлний “хошуу” болон “аймаг” нь хоорондоо ялгаатай ойлголт бөгөөд монголын засаг захиргааны нэгжийн нэр тул орчуулахад төвөгтэй хэдий ч хооронд нь хольж хутгаж болохгүй юм. Иймд хоёр орчуулагч үүн дээр хоёулаа буруу орчуулжээ.

7. “...зэл дээр бариатай гүүнүүд янцааж, айраг найрын цаг мэдэгдэвч...”

“...不时路过的牧人家蒙古包外待挤奶的母马拴满了辄勒绳。虽说正值产马奶酒的旺季...” /Хадцагаан/

“...时时都可遇到系在蒙古包前等待挤奶的母马在嘶鸣。虽知正是痛饮马奶的欢乐季节...” /Цэнь Тяньхуа/

“Зэл” хэмээх нь монгол хэлний үдэсний онцлог бүхий үг бөгөөд “Монгол хэлний их тайлбар толь”-д “дээс, сур зэргийг сунган татаж хоёр үзүүрийг нь гадсанд бэхэлсэн, мал уях хэрэглэл” гэж тайлбарлажээ. Үүнийг Хадцагаан “牧人家蒙古包外待挤奶的母

马拴满了辄勒绳” буюу үгчилэн орчуулбал “малчин айлын гадаа сүүгээ саалгах гүүнүүд зэл дүүргэжээ” хэмээн орчуулсан байна. Эл орчуулгад “зэл” гэдгийг “辄勒绳 буюу zhele уяа” гэж галиглаад “уяа” гэсэн нэрийтгэл үг нэмж орчуулжээ. Харин орчуулагч Цэнь Тяньхуа “系在蒙古包前等待挤奶的母马在嘶鸣” буюу үгчилбэл “гэрийн урд уяж сүүг нь саах гүүнүүд янцгаана” гэж ерөнхий утгаар нь орчуулсан байна. Хадцагаан “зэл”-ийг галиглан орчуулсан бол, Цэнь Тяньхуа огт орчуулалгүй өгүүлбэрийн утганд шингээн орхижээ.

8. “...хуучин сар орой мандах тул, холхи замын чигийг олж ядна...”

“...只可惜月光暗淡, 难以看清前方的路径...” /Хадцагаан/

“...但下弦的月亮很晚才升起, 远处路途的去向却很难辨认...” /Цэнь Тяньхуа/

“Хуучин сар” хэмээхийг “Монгол хэлний их тайлбар толь”-д “билгийн улирлын сүүлчийн хавирган сар” гэжээ. Орчуулагч Хадцагаан “月光暗淡” буюу “сарны гэрэл бүүдийх” гэж орчуулсан бол, Цэнь Тяньхуа “下弦的月亮” буюу “шинийн хорьдын сар” гэж зөв оноон орчуулснаас гадна, цааш нь “很晚才升起” буюу “маш орой манддаг” хэмээн утгыг бүрэн гүйцэд гарган орчуулжээ.

9. “...мөнхүү гэрээс Сүнжидмаа гарч нохой хорих...”

“...松吉德玛从右边的一座蒙古包出来, 为他劝狗...” /Хадцагаан/

“...松吉德玛正从蒙古包中出来, 看住了狗黑夜里...” /Цэнь Тяньхуа/

“Нохой хорих” гэдэг ойлголт монголчуудын хувьд тун ойлгомжтой, манай ахуй соёлтой нарийн холбоотой ойлголт бөгөөд үүнийг орчуулагч Хадцагаан “劝狗” буюу “нохойг ятган болиулах” гэсэншүү утгаар орчуулсан бол, Цэнь Тяньхуа “看住了狗” буюу “нохойгоо хянах” гэх утгаар орчуулжээ. Орчуулагчид аль алин нь “нохой хорих” гэдгийн утгыг ямартаа ч гаргасан бөгөөд хятад хэлнээ ижил төстэй ойлголт байхгүй тул бас ингэхээс өөр аргагүй байсан буй заа.

Дүгнэлт

Д.Нацагдоржийн “Шувуун саарал” өгүүллэгийг дээрх хоёр орчуулагч өөр өөрсдийн арга барилаар орчуулсан нь харагдах бөгөөд монгол ахуй амьдрал, адуу малын явдал зэрэгтэй холбоотой үг хэллэгийг гадаад хэлнээ орчуулахад хүндрэлтэй байх нь тодорхой боловч бас чиг ерөнхий утга санааг боломжийн орчуулсан нь сайшаалтай байна.

Орчуулгын шүүмж судлалд гадаад хэлнээс орчуулсан орчуулгын талаар нэлээд хөнддөг ч монгол зохиол бүтээлийг гадаад хэлнээ хэрхэн орчуулсныг мөн судлан шинжилж, цаашид бүр илүү сайн орчуулан гаргах тал дээр анхаарвал тун ач холбогдолтой хэмээн үзэж байна.

Номзүй:

1. Г.Цогзолмаа, Д.Нацагдоржийн түүвэр зохиол, УБ, 2016
2. Монгол хэлний их тайлбар толь, УБ, 2016